



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 4 өдөр

Дугаар 401

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэхь заалт, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн “ТЭСО ИНВЕСТМЕНТ ҮЦК” ХХК-ийн ажилтан П.Батбаярт үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан гишүүн ҮЦК-ийн ажилтанд Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. “ТЭСО ИНВЕСТМЕНТ ҮЦК” ХХК-ийн ажилтан П.Батбаярт үнэт цаасны арилжаанд оролцох эрхийн үнэмлэх олгох ажил зохион байгуулахыг Захиргаа аж ахуйн алба /Ж.Нарантуяа/-нд, арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Арилжааны алба /Б.Чингүнжав/-д тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.АЛТАЙ